# БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГ

## Хөтөлбөрийн товч танилцуулга

Монгол улс, Бүгд найрамдах Беларусь улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу тэтгэлгээр суралцуулах сонгон шалгаруулалт явагдаж байна. Нийт элсүүлэх оюутны тоо 2-3

## Шалгуур үзүүлэлт

- **Бакалаварын хөтөлбөр(Хугацаа: 3-4 дүгээр сар)**

| | | |
|---|---|---|
| **Тэтгэлгийн хугацаа** | **Бакалаврын зэрэг** | 4 жилийн хугацаатай сургалт |
| **Шалгуур үзүүлэлт** | **Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой;**<br>1. Өргөдөл гаргагч нь 21 нас хүртэлх Монгол улсын иргэн байх.<br>2. Бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээний голч дүн 80-аас дээш, их дээд сургуулийн 1-2-р курст суралцдаг бол голч дүн 3.0 ба түүнээс дээш байх.<br>3. Өмнө нь аль нэг улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх.<br>4. Орос хэлний бэлтгэл бүрэн хангасан байх, эсвэл Монгол Улсын орос хэлний гүнзгийрүүлсэн сургалттай болон ОХУ-тай хамтарсан ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангид 80 ба түүнээс дээш хувийн амжилттай суралцаж байгаа. | |

## Сонгон шалгаруулалтын үйл явц



| | | | |
|---|---|---|---|
| **Цахим өргөдөл (www.esis.edu.mn /grant холбоосоор хандаж цахим өргөдөл бөглөн, дараах баримт бичгийг өргөдөлд татаж оруулна)** | **Бакалаврын сонгон шалгаруулалтыг бичгийн шалгалт болон ярилцлага гэсэн үе шаттай зохион байгуулна.** | **Магистр, докторт суралцахаар шалгуулагчдын сонгон шалгаруулалтыг баримт бичигт үнэлгээ өгөх, ярилцлага хийх хэлбэрээр зохион байгуулна.** | **Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас сонгон шалгаруулалтанд тэнцсэн иргэдийг тухайн орны Засгийн газрын тэтгэлгээр суралцуулахаар нэр дэвшүүлнэ. Хүлээн авах тал тухайн нэр дэвшигчийг суралцуулах тухай эцсийн шийдвэрийг гаргана. Засгийн газрын тэтгэлэгт сургалтын төлбөр ба амьжиргааны тэтгэлэг багтана. Бусад зардал (замын зардал, эрүүл мэндийн даатгал гэх мэт)-ыг суралцагч өөрөө хариуцна.** |

**Дэлгэрэнгүй мэдээллийг авах бол**

- БСШУСЯ-ны www.mecs.gov.mn сайтын гадаадад суралцах хэсгээс авна уу.